




АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНХУТАГ СУМЫН МОНГОЛ АРДЫН
НАМЫН ХОРООНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Уриа: Хүч нэмье



НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Эрүүл иргэн

- 1.1.1. Иргэн бүрийг эрүүл мэндийн багц оношилгоонд жил бүр хамруулна.
- 1.1.2. Сумын эрүүл мэндийн төвийн удирдлага, менежментийг улс төрөөс ангид байлгаж, чадварлаг хүний нөөц, хамт олны дэмжлэгт тулгуурлан томилно.
- 1.1.3. "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийг үргэлжлүүлж, "Хавдрын эсрэг хамтдаа" хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.1.4. Хеликобактеритэй тэмцэх, хянах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.5. Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлэх дэд хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө боловсруулан баталж, хүүхдийн хоолойн архаг (ангина) өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлэх "Эрүүл ирээдүй" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.6. Яаралтай тусlamжийн чанарыг дээшлүүлж, түргэн тусlamжийн автомашины парк шинэчлэлтийг бүрэн хийнэ.
- 1.1.7. Эрүүл мэндийн салбар, эмнэлгийн албан хаагчдын ажиллах орчинг сайжруулан, сумын ЭМТ-ийн хүний нөөцийг бодлогоор дэмжин тогтворт суурьшилтай ажиллуулах
- 1.1.8. Сумын эмнэлгийн их засварыг хийж, халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно.
- 1.1.9. Иргэдэд эрүүл мэндийн бүх талын боловсролыг ЕБС-д суралцаж байх үеэс олгож, эрүүл мэндийн "анхны тусlamж" үзүүлэх чадавхийг хүн бүрд эзэмшүүлнэ.
- 1.1.10. Биеийн тамир спортын мэргэшлээр хүний нөөц бэлтгэх, орон нутгийн хэрэгцээ хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сурган ажлын байраар хангах.
- 1.1.11. Сумын эрүүл мэндийн төвийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд сэргээн засах, физик эмчилгээний тоног төхөөрөмж, ЭХО аппараттай болгох

1.2. Боловсрол

- 1.2.1. Ерөнхий Боловсролын Сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлээмжийг үнэлэх аймгийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.2.2. Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулж, "Чадварлаг багш" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, багш нарыг урамшуулах
- 1.2.3. Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн сонгон шалгаруулж томилно.
- 1.2.4. Яслийн үйлчилгээ, хамрах хүрээг нэмэгдүүлж, Ясли цэцэрлэгийн цогцолборыг шинээр бий болгоно.
- 1.2.5. ЕБС-ийн байрны их засвар
- 1.2.6. Сурагчдын сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 1.2.7. Ногоон хөгжлийн байгууламж, урлагийн заал, цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг тохижуулж, тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй суралцагчдад зориулсан тохируулгат орчин бүрдүүлнэ.
- 1.2.8. Цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбайг стандартын дагуу тохижуулах
- 1.2.9. Сурагчдын дунд массын олимпиад зохион байгуулж, амжилттай оролцсон сургууль, 2317144297
анги хамт олон, багшийг урамшуулж алдаршуулна. 0A0046 90740
- 1.2.10. Ном унших, номын санг олон нийтэд хүртээмжэйгээр байгуулах түүгээр үйлчлэх санал санаачлагыг дэмжих, ном уншсан хүүхэд иргэдийг урамшуулах, дотоодод аялуулж, ном унших хөдөлгөөнийг өргөжүүлнэ.
- 1.1.11. Сумын иргэдийн мэргэжлийн боловсрол эзэмших идэвх санаачилгыг дэмжинэ.
- 1.2.12. Монгол бичиг төрийн бичиг болохтой холбогдуулан иргэдийн үндэсний бичгээ сурах санал санаачилгыг дэмжиж ажиллана.
- 1.2.13. Өрх бүр угийн бичиг хөтлөг болох аянг эрчимжүүлнэ

1.3. Хүүхэд хамгаалал, хөгжил

- 1.3.1. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшилтийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.3.2. Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, хурд сааруулагч, камертай болгоно.

1.3.3 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.

1.3.4 Гэр бүлийн Хүчирхийлэл болон хүүхэдтэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгож төвийн байр байгуулна.

1.3.5 Орон сууцыг хувийн хэвшилийн оролцоогоор шинээр байгуулан түүнд хүүхдийн тоглоомын стандартад нийцсэн талбай бий болгоно.

1.3.6 Сумандаа хүүхдийн хөгжил, нийгмийн төлөвшилт, оролцоог сайжруулах зорилгоор "Хөдөлмөр зуслан" байгуулна.

1.3.7 Хамтын ажиллагаатай сум, сургуультай багш, сургач солилцооны хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хүүхэд хамгааллын баг болон хүүхдийн элчийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

1.4. Тогтвортой амар амгалан гэр бүл

1.4.1 Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалд тулгуурлан хүнсний талон зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

1.4.2 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

1.4.3 Гэр бүл, өрхийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5. Залуучуудын хөгжил

1.5.1. Хүүхэд, залуучууд, өсвөр үеийнхнийг гадны серөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.5.2. Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн "Залуу гэр бүл" дэд хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

1.5.3. Залуучууд, залуу гэр бүлийг малжуулах төсөлд хамруулна.

1.5.4. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх /гэрэлт/ цэцэрлэгт хүрээлэнг бий болгох

1.5.5 Залуучуудын зөвлөл, сайн дурын санаачлагыг дэмжинэ.

1.5.6 Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.5.7 Орлого багатай өрхийн ажил эрхлээгүй насанд хүрсэн гишүүдийг бүртгэлжүүлж, мэргэшил эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

1.6. Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ

1.6.1. Ахмадын хөгжлийн аймгийн дэд хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

1.6.2. Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.

1.6.3. Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх ахмадын төвийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

1.6.4. Сумын ахмадын хөгжлийн сан байгуулна.

1.6.5 Байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмадуудыг сувилалын үйлчилгээнд хамруулна.

1.6.6 "Ахмадаа хүндэтгээ" арга хэмжээг тогтмолжуулна.

1.7. Үнэдэсний баархал, өв соёл, спорт

1.7.1 Баянхутаг сумын онцлог, соёл иргэншил, үнэт зүйлийг танилцуулсан өв, соёл, урлаг, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.7.2 Соёл, урлаг, оюуны болон спортын төрлөөр олонд танигдсан "Баянхутаг брэнд"ийг дэмжиж, Баянхутагын баархлыг төлөвшүүлнэ.

1.7.3 Баянхутаг sumaас төрөн гарсан алдартнуудын амьдрал, гавьяа зүтгэлийг бүтээлийг сурталчилсан Баянхутагын түүхийн ном товхимолыг шинээр гаргана.

1.7.4 Олон улсын стандартын шаардлагад нийцсэн "Морин тойруулга"-ын зураг төсөл хийх

1.7.5 Түүх, соёлын өвийг устгаж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.

1.7.6 Сумын музейн үзмэрийн санг нэмэгдүүлнэ.

1.7.7 "Тайган нохой" эвент арга хэмжээг жил бүр зохион байгуулах.

1.7.8 "Сумын соёлын төвийг МУУГЗ, хөгжмийн зохиолч П.Бадарчийн нэрэмжит болгон хөгжүүлж, дэргэдээ аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох боломжийг бүрдүүлнэ.

1.7.9 "Монгол бичгээ сурх, сурталчлах хөдөлгөөн"-ийг нийт иргэд, өргөн түмнийг хамруулан жишиг болохуйцаар төлөвлөн далайцтай, ач холбогдол өгч өрнүүлнэ.

1.7.10 Сумын яруу найрагт дурлагсадын наадмыг ивээлдээ авч 2 жил тутам хийж байна.

1.7.11 Төрийн шагналт, Ардын жүжигчин, Хөдөлмөрийн баатар хөгжмийн зохиолч Д.Лувсаншаравын нэрэмжит "Хурдан зээрд" дууны наадмыг 2 жилд нэг удаа зохион байгуулах

1.7.12 Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

1.7.13 Спорт заалыг магадлан итгэмжлэлд хамруулан гэрчилгээжүүлж спортын клубд хамрагдаж спортоор хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлнэ.

ХОЁР : ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГ

2.1. ХАА-н чиглэл

2.1.1 Хөдөө аж ахуйн салбарт малчидын залгамж халааг бэлтгэх "Илгээлтийн эзэн – III" аяныг сумандаа хэрэгжүүлнэ.

2.1.2 Мал, амьтны гаралтай арьс, шир, ноос боловсруулж, оёмол, сүлжмэл, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх иргэдийг дэмжиж, түүхий эдээ эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.3 Малын толгой шийр гэдэс дотор дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж тухайн чиглэлийн төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

2.1.4 Малын эмч, мал зүйч, ХАА газар тариалангийн мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх бодлого гаргаж ажиллана.

2.1.5 Төмс хүнсний ногоо тариалагчдыг дэмжин Орон нутагт тариалсан төмс хүнсний ногоогоор сумын иргэдээ бүрэн хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.6 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, генетик нөөцийн тухай хуулийн

2.1.7 Малыг ялган тэмдэглэх, малыг им тамга, тэмдэг, зүсмийн бүртгэлд бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, сумын мэдээллийн нэгдсэн сантай болно.

2.1.8 Халдварт өвчинтэй тэмцэх, мал сүргийг бүрэн вакцинуулах дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулна.

2.1.9 Сүү, махны чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжиж хурай сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөх, төсөл хөтөлбөрт хамруулан бодлогоор дэмжин ажиллана.

2.1.10 Төмс хүнсний ногоо тариалагчдыг дэмжин Орон нутагт тариалсан төмс хүнсний ногоогоор сумын иргэдээ бүрэн хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.11 Царгас зэрэг тэжээлийн ургамал тариалах санаачлагыг дэмжин хувийн хэвшилтэй хамтран малын хорголжин тэжээлийн үйлдвэрийг байгуулах

2.1.12 Орон нутгийн иргэний бие даасан, бүтээлч байдлыг дэмжих зорилгоор "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" аяныг өрнүүлэх, удирдан зохион байгуулна.

2.2. Төрөлжсөн аялал жуулчлал

2.2.1 Нутгийн онцлог, ялгарал бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдийг түшиглэсэн тогтвортой эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

2.2.2 Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.2.3 Аялал жуулчлалын гол чиглэлийн авто зам дагуу түр буудаллах үйлчилгээний цогцолбор байгуулна.

2.2.4 Түүх, соёлын үнэт өв болон байгалийн үзэсгэлэнт Сэргэн хаалганы бичээс, Баянхүрээ, Чингисийн гаралт, Хүүхдийн хөшөө зэргийг хамарсан аялал жуулчлалын маршрутыг түшиглэн аялал жуулчлалын "ЭКО АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ" хөтөлбөрийг боловсруулж, бус нутгийн хэмжээнд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулна..

2.2.5 Аялал жуулчлалд зориулсан "БАЯНХУТАГ БРЕНД" дэд хөтөлбөрийг үргэлжлүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн шошгожуулна.

ГУРАВ : ҮНДЭСНИЙ ДЭД БҮТЦИЙН СҮЛЖЭЭ

3.1. Эрчим хүчний төсөл

3.1.1. Сумын шинэ суурьшлын бусэд цахилгаан дамжуулах шугам татах

3.2. Авто зам

3.2.1. Сумандаа 1 км хүртэлх стандарт шаардлагад нийцсэн гэрэлтүүлэг, явган, дугуйн зам бүхий зам барих ажлыг үе шаттай эхлүүлнэ.

3.3 Дэд бүтэц

3.3.1.. Төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвортой суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч анх удаа орон сууцны зээл авч байгаа нийгмийн даатгалын шимтгэл төлдөг иргэдэд урьдчилгаагүй, бага хүйтэй зээлийн хөтөлбөрт хамрагдах, анх удаа байр авч байгаа бага, дунд орлоготой иргэдэд 4-6 хувийн хүйтэй орон сууцны ипотекийн зээл олгох Засгийн газрын бодлогыг дэмжин ажиллана.

3.3.2. Орон сууцны төлөвлөлтөд ногоон байгууламж, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлнэ.

3.3.3. Төрийн албан хаагчидын нийтийн байрыг инженерийн шугам сүлжээнд холбуулан их засварыг хийх.,

3.3.4. Сумын хүн амын орлогод нийцсэн, ногоон хөгжлийн загварт тохирсон орон сууц нийлүүлэлтийг бодлогоор дэмжинэ.

3.3.5. Гэр хорооллын өрхийн газрыг өөрсдийн нь идэвх, санаачилга, оролцоонд тулгуурлан дахин зохион байгуулах, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, ногоон байгууламж бий болгох үйл ажиллагааг бодлогоор дэмжих, улсын төсөв болон бусад хуулиар хориглоогүй эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжийг бий болгоно.

3.3.6. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

4.1.1 Багийн төвийг шинээр барьж жишиг баг болгоно.

4.1.2 Багуудын төвийн гадна тохижилтыг хийнэ.

4.1.3 ЗДТГ-ын барилгыг шинээр барина.

4.2 ШУДРАГА ЗАСАГЛАЛ

4.2.1 Сонгуулийн үр дунд томилогдсон, сонгогдсон албан тушаалтуудтай батламж гэрээ байгуулж хариуцлагатай ажиллана.

4.2.2 Төрийн албан хаагчдыг чадавхжуулж, хүнд сурталгүй төрийн үйлчилгээ нэвтрүүлэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

4.2.3. Орон нутгийн хөгжлийн сан, бусад нийтийн эрх ашигт үйлчилдэг сангийн үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.

4.2.4 Төрийн байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл, хамгаалалтын байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, холбогдох арга хэмжээ, хариуцлага тооцож ажиллана.

4.2.5 Төрийн албан хаагчдын интернет орчин /фэйсбүүк, сошиал/-д ажиллах цагийг хязгаарлах, ажлын цагт сошиал сүлжээнд орохгүй болгоно.

4.2.6 Төрийн бодлого, дүрэм, журам боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих цахимаар оролцох боломжийг өргөжүүлнэ.

4.2.7 Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно.

4.3. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба

4.3.1. Архи согтууруулах ундаа хэрэглэх байдлыг төрийн аль ч шатны байгууллагад таслан зогсоох, архигүй орчин бүрдүүлэх, ажлын цаг, албан томилолтой үед архи уусан албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх асуудлыг сумын хэмжээнд зарлана.

4.3.2. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

4.3.3. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

4.3.4. Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг эрс шинэчилнэ.

4.3.5. Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг бодитоор хэрэгжүүлнэ.

23171442
ОА0046 90

4.4. Ардчилсан, хүний эрхийг дээдлэх

- 4.4.1. Төрийн байгууллага, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендерийн мэдрэмжтэй бодлого хэрэгжүүлнэ.
- 4.4.2. Сумын төвийн гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоо ажлыг эрчимжүүлнэ.
- 4.4.3. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, орон нутгийн авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтыг сайжруулна.

ТАВ : НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1 Баталгаат ундны ус

5.1.1. Сумын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг шинэчлэн өргөтгөж, баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлнэ.

5.1.2. Хиймэл цөөрөм, хөв байгуулах, гадаргын ус ашиглах санаачлагыг дэмжинэ.

5.2 Эко ногоон хөгжил

5.2.1 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

5.2.2 Сумын төвийн ногоон байгууламжууд, зүлэгжилтийг стандарт шаардлагад нийцүүлэн, хогийн ургамлаас салгах, ургаа модыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрүүлжүүлэх, модыг загвар оруулж хэлбэржүүлэх ажлыг мэргэжлийн түвшинд хийнэ.

5.2.3. "Ногоон хэрэм" төсөл хэрэгжүүлж, дэд бүтцийн байгууламж, бэлчээр ашиглалтын улмаас эвдрэл, доройтолд орсон газрыг нөхөн сэргээж дахин ашиглах боломжтой болгоно.

5.2.4. Сумын төвийн ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг 15 хувьд хүргэнэ.

5.2.5. Сумын төв рүү орох 200 м хүртэлх замыг ногоон байгууламжтай болгох ажлыг эхлүүлнэ.

5.2.6. Цөлжилтийг бууруулж, бэлчээрийг доройтлоос сэргийлэх чиглэлээр сумын хэмжэний судалгаа, тооцоог гаргана.

5.2.7. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлнэ.

5.2.8. Бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд халгүй аргаар тэмцэж, холбогдох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

5.2.9. Бэлчээрийн доройтлыг бууруулах газар зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж, зохистой ашиглан хамгаалж, нөхөн сэргээнэ.

5.2.10. Бэлчээрийг нөхөн сэргээх "Малчдын дундын сан"-г бий болгоно.

5.2.11. Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар эхлүүнэ.

5.2.12. Тогтвортой ногоон сүм, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжин хөгжүүлнэ.

ЗУРГАА : ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6.1. Орон нутгийн хөгжил

6.1.1. Бий болсон бүтээн байгуулалт, хөгжлийн хөтөлбөрүүдийн цаашдын хөгжил, ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, бүртгэл хяналтыг нэмэгдүүлж, салбар хоорондын уялдааг ханган ажиллана.

6.1.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилт, хяналт, иргэдийн оролцоог сайжруулан эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

6.1.3. Сумын төвд байгаа хуучирч муудсан, эзэн эзэмшил, цаашид хэрхэх нь тодорхойгүй, иргэд олон нийтийн аюулгүй амгалан байдалд сөргөөр нелөөлөхүйц Тэмцэл нэгдлийн складын барилгыг төр, хувийн хэвшилийн хамтын ажиллагаагаар засварлан эдийн засаг, нийгмийн эргэлтэд оруулна.

6.1.4. Тендер хөрөнгө оруулалтын төсөв, шалгаруулалтыг ил тод нээлттэй зохион байгуулах, асуудал маргаангүй шийдвэрлэх бүх боломжийг бий болгох, хариуцлагажуулна.

6.2. Хот хөдөөгийн тэнцвэртэй хөгжил

6.2.1 Улсын чанартай зам дагуу худалдаа, үйлчилгээний төв байгуулж, орон нутгийн бүтээгдэхүүнийг борлуулах боломжийг бүрдүүлнэ.

6.2.2 "Сумын хөгжил – Жишиг сум" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.2.3 Сумын халуун усны барилгад засвар үйлчилгээ хийж, нийтийн ахуйн үйлчилгээний дэд бүтцийг сайжруулна.

6.2.4 Сумын цэвэр усны худгийг SMART картын системд холбоно.

Батлав:

Хэнтэй аймгийн Баянхутаг сумын
Монгол Ардын намын хорооны дарга

Д.Байгалмаа
Д.Байгалмаа

